


Төрийн албаны зөвлөлийн
2022 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн
86 дугаар тогтоолын 17 дугаар хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн
Боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан
огноо:

Байгууллагын нэр:

Эрүүл мэндийн яам

Нэгжийн нэр:

Нийтийн эрүүл мэндийн газрын Халдварт
бус өвчний хэлтэс

Албан тушаалын нэр:

Халдварт бус өвчний хяналт,
сэргийлэлт, эрт илрүүлэг хариуцсан
шинжээч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Шинжээч, ТЗ-9

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпын гудамж 2, Засгийн газрын VIII
дугаар байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлгийн тандалт, сэргийлэлтийн талаар
бодлого боловсруулж, хэрэгжилтийг хангуулах чиг үүргийг хэрэгжүүлж гүйцэтгэлийн үр
дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Зонхилон тохиолдох халдварт бус өвчний бодлогыг хэрэгжүүлэх, хяналт тавих, мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгөх, нэгдсэн удирдлагаар хангах;
2. Эрт илрүүлгийн бодлогын хэрэгжилтийг төлөвлөх, гүйцэтгэлд хяналт тавих, нэгдсэн удирдлагаар хангаж тайлагнах;
3. Нийгмийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны бодлогын хэрэгжилт, нэгдсэн уялдаа холбоог хангах;
4. Тухайн асуудлын чиглэлээр салбарын, салбар хоорондын болон олон улсын хамтын ажиллагааны нэгдсэн удирдлагаар хангах;
5. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, байгууллагын болон нэгжийн дотоод ажилд оролцох, удирдлагаас хууль ёсны хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх -Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулах чиглэлээр хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох бодлогын хэрэгжилтийг зохицуулах, хяналт тавих;	Хууль эрх зүйн орчин сайжирч, бодлогын хэрэгжилт хангагдсан байна.	Г,Х
	2.Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсээс хүн амын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтийг зохицуулах;	Мэргэжил арга зүйн удирдлагаар хангасан байна.	Г,Х
	3.Халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулах талаар сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулахад арга зүйн удирдлагаар хангах;	Сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулахад арга зүйн удирдлагаар хангагдсан байна.	Г,Х
	4.Энэ чиглэлээр гадаад, дотоодын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт, зохицуулалт, тайлагнах;	Төсөл хөтөлбөрүүдийн зохицуулалт сайжирч, шалгуур үзүүлэлтийн биелэлт хангагдана.	Г,Х



	5.Энэ чиглэлээр бусад салбар, төрийн ба төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах.	Хамтын өргөжиж, ажиллагаа оролцоо хангагдсан байна.	Г,Х
2 дугаар зорилтын хүрээнд	1.Хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үйл ажиллагааны хууль эрх зүйн орчинг дэмжих, боловсронгуй болгох, бодлогын хэрэгжилтийг төлөвлөх;	Хууль эрх зүйн орчин сайжирч, бодлогын хэрэгжилт нэгдсэн удирдлагаар хангагдана.	Г,Х
	2.Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн ажлыг зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах;	Мэргэжил арга зүйн удирдлага, бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хангагдана.	Г,Х
	3.Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх, ач холбогдлын талаар сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулахад арга зүйн удирдлагаар хангах;	Сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулахад арга зүйн удирдлагаар хангагдсан байна.	Г,Х
	4.Энэ чиглэлээр гадаад, дотоодын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт, зохицуулалт, тайлагнах;	Төсөл хөтөлбөрүүдийн зохицуулалт сайжирч, шалгуур үзүүлэлтийн биелэлт хангагдана.	Г,Х
	5.Энэ чиглэлээр бусад салбар, төрийн ба төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах.	Хамтын ажиллагаа өргөжиж, оролцоо хангагдсан байна.	Г,Х
3 дугаар зорилтын хүрээнд	1.Нийгмийн эрүүл мэндийн төвийн хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоход хамтран ажиллах;	Бодлого, хуулийн хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм, журмыг боловсруулж гаргасан байна.	Г,Х



	2.Нийгмийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;	Мэргэжил арга зүйн удирдлага, бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хангагдана.	Г,Х
	3.Энэ чиглэлээр гадаад, дотоодын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт, зохицуулалт, тайлагнах;	Төсөл хөтөлбөрүүдийн зохицуулалт сайжирч, шалгуур үзүүлэлтийн биелэлт хангагдана.	Г,Х
	4.Энэ чиглэлээр бусад салбар, төрийн ба төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах.	Хамтын ажиллагаа өргөжиж, оролцоо хангагдсан байна.	Г,Х
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Салбарын болон бусад салбар, төрийн ба төрийн бус байгууллага, олон улсын байгууллага хоорондын хамтын ажиллагааг хангах чиглэлээр хууль эрх зүйн орчинг дэмжих, боловсронгуй болгох;	Хууль эрх зүйн орчин сайжирна.	Г,Х
	2.Хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, нэгдсэн удирдлагаар хангах.	Хамтын ажиллагаа өргөжиж, бодлогын хэрэгжилт нэгдсэн удирдлагаар хангагдана.	Г,Х
5 дугаар зорилтын хүрээнд	1.Хариуцсан асуудлын хүрээнд яамны болон төрийн жинхэнэ албан хаагчийн тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, тайлагнах;	Нэгжийн тайлан, мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргасан эсэхэд хяналт тавьж, дүгнэсэн байна.	Г
	2.Удирдлагууд болон холбогдох байгууллагыг мэдээллээр хангах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх;	Мэдээлэл, мэргэжил арга зүйн туслалцаа нь хууль, тогтоомжинд нийцсэн бодитой байна.	Г,Т
	3.Архив, албан хэрэг хөтлөлт, тайлан, мэдээг цаг тухайд нь тайлагнах, хяналт тавих;	Албан хэргийн стандартын дагуу хөтөлсөн байна.	Г
	4.Удирдлагаас хариуцуулсан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;	Үүрэг даалгаврыг хугацаанд нь чанартай гүйцэтгэсэн байна.	Г,Т



	5.Нэгжид ирсэн албан бичиг, өргөдөл, хүсэлтийг судалж, шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулалтад хяналт тавих.	Шийдвэрлэх үйл ажиллагаа хуульд нийсэн байна.	Х, Г
III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх		
Мэргэжил	- эрүүл мэнд /091/.		
Мэргэшил	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх		
Туршлага	Төрийн албанд 8 жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх.		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах, харьцуулан судлах; - тогтоол, шийдвэрийн хэрэгжилт дэх нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах; - албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх; - нэгжийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцох, үр дүнг тайлагнах; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд гаргасан шийдвэрийн шууд ба шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарыг зөвлөх; - бусад 	
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчлэх; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд хуульд нийцсэн, оновчтой шийдвэрийг шуурхай гаргах; - асуудлыг хууль тогтоомж, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - гаргасан шийдвэрийнхээ талаар хариуцлага хүлээх; - бусад. 	
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах, үлгэрлэн манлайлах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч харилцаа бий болгох; - ажил хэрэгч, бүтээлч, санаачлагатай ажиллах; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтын хувьд бусдыг манлайлах - бусад 	
	Бусад	<ul style="list-style-type: none"> - албан хэрэг хөтлөх, бодлогын баримт бичиг боловсруулах; 	



		<ul style="list-style-type: none"> - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн технологийн дэвшилтэт аргыг ашиглах; - бусдад хүндэтгэлтэй, соёлтой, адил тэгш хандах; - кирил болон үндэсний бичгээр албан бичиг боловсруулах чадвартай байх.
--	--	--

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Нийтийн эрүүл мэндийн газрын Халдварт бус өвчний хэлтсийн дарга

<u>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u>	<u>Бусад харилцах субъект</u>
	<ul style="list-style-type: none"> - Засгийн газрын хэрэг эрхлэх газар, яам, агентлаг, бусад төрийн байгууллагын газар, хэлтэс, нэгжийн холбогдох албан тушаалтан; - Олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөр, төрийн бус байгууллагын холбогдох ажилтан; - Мэргэжлийн байгууллага, хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтан, иргэн.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u>
---	--

<u>Албан тушаал:</u> ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА <i>П.Эрхэмбаяр</i>/П.ЭРХЭМБАЯР/ 2022 оны <i>03</i> дугаар сарын <i>15</i> -ны өдөр	<u>Байгууллагын нэр:</u> ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ <u>Шийдвэрийн огноо:</u> <i>22 03 01</i> <u>Дугаар:</u> <i>086</i>
--	---

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:
 ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
 Шийдвэрийн огноо:
 Дугаар:
 (тамга/тэмдэг)
 ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА *Ц.Эрдэмбилэг* /Ц.ЭРДЭМБИЛЭГ/
 2022 оны *03* дугаар сарын *15*-ны өдөр

